

**БООЦООТ ТААВАР, ХОНЖВОРТ СУГАЛААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 01 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн баримтлах нийтлэг шаардлагуудыг тогтоох, бооцоот таавар болон хонжворт сугалааны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, хариуцлага, хориглох үйл ажиллагаа, төрийн зүгээс тавих хяналтын тогтолцоо болон бооцоот таавар, хонжворт сугалаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд аливаа төрлийн хүлээх үүрэг, зардал үүсэхгүй бөгөөд төрийн байгууллага болон тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тодорхой зардал үүснэ гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг D-parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хонжворт сугалааг мөрийтэй тоглоом гэж томъёолох нь зөв эсэх, гэр бүл, найз нөхдийн хүрээнд мөрий тавьж тоглож байгаа нь энэ хуулийг зөрчиж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

A handwritten signature in blue ink is written over a red rectangular stamp. The signature is stylized and appears to be 'Ц.Мөнх-Оргил'. The stamp contains some faint, illegible text.

Ц.МӨНХ-ОРГИЛ